



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/32

Мандалговь

**“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай**

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/33 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын дотоод журмын 6.4.1 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн үйл ажиллагааг “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриан дор 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулсугай.
2. Үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Үйл ажиллагаанд зарцуулагдах 1.500.000 (Нэг сая таван зуун мянга) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.
4. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, даргын дэргэдэх зөвлөлд 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд), гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



ГАНЗОРИГ

431190071